



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 64

Арвайхээр

Г Хөтөлбөр батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, Соёлын тухайн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэ Зуу” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эрдэнэ Зуу” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.


3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн Бодлогын хэлтэс /Б.Сайнжаргал/, Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар /Ж.Пүрэвсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  А.ИШДОРЖ

20190923  
130128



Аймгийн ИТХ-ын Төргүүлэгчдийн  
2019 оны 09 дүгээр сарын 23 -ны өдрийн  
64 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



## “ЭРДЭНЭ ЗУУ” ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан бөгөөд Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын баримт бичигт соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, бүртгэн баримтжуулах, судлах, сурталчлах талаар тодорхой заасан.

Эрдэнэ Зуу нь XVI зууны сүүлээр Монголын эзэнт гүрний нийслэл Хархорумын туурин дээр баригдан өнөөг хүртэл Монголын буддын шашны түүхийн ховор нандин хосгүй үнэт зүйлсийг хадгалсан түүх соёлын томоохон төв төдийгүй ЮНЕСКО-ийн 1972 оны “Байгаль соёлын өвийг хамгаалах” конвенцийн шалгуураар 2004 онд Дэлхийн өвд бүртгэгдсэн түүх соёлын цогцолбор газрын хосгүй үнэт дурсгалын нэг юм.

Эрдэнэ Зуу нь өнөөдөр музейн үйл ажиллагаа явуулж гадаад, дотоодын олон жуулчдад үйлчилгээ үзүүлэхээс гадна шашин номын зан үйл тогтмол явагдаж байдаг онцлогтой. Эрдэнэ Зуу музей нийт 8 барилга байгууламжид үзмэр, эд өлгийн зүйл дэлгэн музейн үйлчилгээ үзүүлж, Лаврин сүмд шашин номын үйл ажиллагаа явуулж байна. Музейн сан хөмрөгт 7,4 мянган үзмэр цуглуулга бүртгэлтэй байдаг. Хосгүй үнэт үзмэрийн эзлэх хэмжээ нийт үзмэрт 1,6 % байна.

Үзмэрийн 8 танхим, түр үзэсгэлэнгийн 1 танхимд нийт үзмэрийнхээ 30 орчим хувийг дэлгэн олон нийтийн хүртээл болгож байна.

Иргэд үзмэр эд өлгийн зүйлсэд гараар хүрэх, адис авах, хадаг, идээ цагаа өргөх, түрхэх, зул хүж мандаах зэргээр дурсгалт зүйлийн аюулгүй байдалд байнгын аюул занал учруулдаг.

Сан хөмрөг, үзэсгэлэнгийн танхимын хяналтын камерийн хүчин чадал хангалтгүй, дүрс ялгах, дагаж бичих бололцоогүй, бичлэгийн төхөөрөмжийн багтаамж бага, серверийн тусгай өрөө тасалгаагүй байна. Менежерийн ажлын өрөөг энэ зориулалтаар ашиглаж байгаа нь нэгдүгээрт: нууцлал хангагдаагүй, хоёрдугаарт: агааржуулалтын систем хангагдаагүй гэж мэргэжлийн хяналтын газар дүгнэсэн.

Эрдэнэ Зуу музейн дүрэм, бүтэц зохион байгуулалтыг Өвөрхангай аймгийн Засаг даргын 2012 оны А/169 дүгээр захирамжаар батлахдаа орон тооны дээд хязгаарыг 26 байхаар тогтоосон. Одоогийн байдлаар 23 хүний орон тоогоор ажиллаж байгаа бөгөөд 43,3% нь мэргэжлийн, бусад нь аж ахуй, харуул хамгаалалтын ажилтнууд байна. Аялал жуулчлалын оргил ачаалалтай үед илүү цагаар ажиллаж орлогын төлөвлөгөөг тогтмол давуулан биелүүлдэг боловч музейн ажиллагсдын урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх механизм



бүрдээгүй байна. Одоо мөрдөж буй бүтэц, орон тоо нь 2012 онд батлагдсан бол, 2018 оны байдлаар музейн тайлбар таниулга, бусад үйлчилгээ авч байгаа үзэгч, үйлчлүүлэгчдийн тоо тэр үеийнхээс 2 дахин нэмэгдсэн байна.

Түүх соёлын үнэт өв болох Эрдэнэ Зуу музейд олон зуун жилийн өмнө бүтээгдсэн дурсгалт барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлүүд хадгалагдаж, олон нийтийн хүртээл болгон сурталчлан таниулж байгаа тул үзмэр хадгалах нөхцөл, сэргээн засварлалт, харуул хамгаалалт, ажиллах хүчний хүрэлцээ хангамж, чадавхийг сайжруулах цогц бодлого, үйл ажиллагаа шаардлагатай байна.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго.**

Эрдэнэ Зуу цогцолборын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдал, орчны тохижилт, үйлчилгээг өнөөгийн тавигдаж буй шаардлага, стандартын хэмжээнд хүргэн хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлж, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахуйц соёл, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ.

### **2.2. Хөтөлбөрийн зорилт.**

2.2.1 Эрдэнэ Зуу музейн барилга байгууламжид үзүүлж буй сөрөг нөлөөллийн хүчин зүйлсийг тодорхойлох, шинжилгээ судалгааг бодитой хийж, үр дүнг нь ашиглах нөхцөл бүрдүүлэх.

2.2.2 Барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлийг арчлан тордох, бэхжүүлэлт хийх, сэргээн засварлах хэрэгцээг тасралтгүй хангах хөрөнгө санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх.

2.2.3 Үзмэр эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлыг хангахад ашиглагдах техник хэрэгсэл, хүний нөөцийг улсын онцгой объектод тавигдах нөхцөл шаардлагын хэмжээнд хүргэх.

2.2.4 Музейн үйлчилгээ, үйл ажиллагаанд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

2.2.5 Мэргэжлийн чадавхи, бүтээлч үйл ажиллагаа, үр дүн, бодитой урамшуулалд суурилсан зарчмыг мөрдүүлэх замаар хүний нөөцийн хөгжлийг хангах.

## **Гурав. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, аргачлал, үр дүн**

3.1. Эрдэнэ Зуу музейн барилга байгууламжид үзүүлж буй сөрөг нөлөөллийн хүчин зүйлсийг тодорхойлох шинжилгээ судалгааг бодитой хийж, үр дүнг нь ашиглах нөхцөл бүрдүүлэх.

3.1.1 Барилга байгууламж, үзмэр цуглуулгын чанар, аюулгүй байдалд үзүүлж буй орчны болон ашиглалтын нөхцлөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийн үнэлгээг тогтоолгох төсөл хэрэгжүүлэх.

3.1.2 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх.

3.1.3 Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг батлан мөрдлөг болгох.

3.1.4 Шаардлагатай зардал төсвийг улс, орон нутгийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх.



3.2. Барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлийг арчлан тордох, бэхжүүлэлт хийх, сэргээн засварлах хэрэгцээг тасралтгүй хангах, хөрөнгө санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх.

3.2.1 Барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлийн сэргээн засварлалтын хэрэгцээг шаардлагатай объект, өв бүрээр гарган эрэмбэлж улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж батлуулах.

3.2.2 Сэргээн засварлах, арчлан тордох үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн тооцоо, санхүүжилтийн хэлбэрийг урьдчилан тогтоож, тухайн оны төсөвт тусгуулан шийдвэрлэдэг зарчим тогтоож мөрдөх.

3.2.3 Музейн дэргэд дурсгалт барилга байгууламж, үл хөдлөх өвийг арчлан тордох, бэхжүүлэлт, урсгал засварын ажлыг тогтмол явуулах чадавхи бүхий мэргэжлийн мэргэжсэн баг байгуулж ажиллуулах.

3.2.4 Үзмэр эд өлгийн зүйлийн сэргээн засварлалтын хэрэгцээг хангах асуудлыг Соёлын өвийн үндэсний төвтэй жил бүр “Хамтран ажиллах гэрээ” байгуулан мөрдөх замаар шийдвэрлэх.

3.3. Үзмэр эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлыг хангахад ашиглагдах техник хэрэгсэл, хүний нөөцийг улсын онцгой объектод тавигдах нөхцөл шаардлагын хэмжээнд хүргэх.

3.3.1 Музейн харуул хамгаалалтын үүргийг цагдаагийн эсвэл мэргэжлийн хамгаалалтын албанд шилжүүлэх.

3.3.2 Телекамераар хянах талбайн хэмжээгээ үе шаттайгаар нэмэгдүүлэх.

3.3.3 Дохиоллын системийн ажиллагааны найдвартай байдал, бичлэгийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, багтаамжийг сайжруулах.

3.3.4 Гал унтраах автомат ажиллагаатай багаж төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх.

3.3.5 Сан хөмрөгийн өрөө тасалгааг өргөжүүлж, тавиур, сейфний тоог нэмэх, үзмэр цуглуулгыг төрөлжүүлэн хадгалах.

3.3.6 Сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх, үзмэр зөөж тээвэрлэх, шаардлага гарсан тохиолдолд ашиглах зориулалт бүхий тусгай хайрцаг сав бэлтгэх.

3.3.7 Үзэсгэлэн болон үзмэрийн танхимуудын шилэн хорго, хаалт ханыг боловсронгуй болгон шинэчлэх.

3.3.8 Үзмэр цуглуулгын орчны дулаан, чийгшил хэмжих багаж төхөөрөмжийн хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх.

3.4 Музейн үйлчилгээ, үйл ажиллагаанд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

3.4.1 Угтах орчны тохижилт /зам талбай, сандал сүүдрэвч, дурсгалын зураг татуулах тавцан г.м/

3.4.2 Хэрмийн дотор талбайд байрлуулсан мэдээлэл, сурталчилгааны самбаруудыг сайжруулах, шаардлагатай таних тэмдэг тэмдэглэгээг хийж байрлуулах.

3.4.3 Музейн ерөнхий болон үзүүллэгт байгаа үзмэрийн тайлбарыг агуулга, зохиомжийн хувьд боловсронгуй болгох.

3.4.4 Аудио хөтөчийн үйлчилгээг нэвтрүүлэх, мөн аман тайлбарыг орос, япон, хятад хэл дээр хүргэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

3.4.5 Виртуаль орчинд дахь үзүүллэгийн агуулга, хүртээмжийг нэмэгдүүлэх.

3.4.6 Эрдэнэ Зуу музейн үзмэр эд өлгийн зүйлийн танилцуулгыг интернетийн орчинд сурталчлах цахим контентийг нэвтрүүлэх.



3.4.7 Бурхан шашны соёлын бодит өвийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хийдтэй хамтран тусгайлсан орчинд явуулах.

3.4.8 Тусгай үзэгчдэд /буддистууд, бурханы шашин судлаач нар, энэ чиглэлийн оюутан сурагч / ламаар музейн тайлбар хийлгэх.

3.4.9 Хийдийн нандин сахиус, бусад хосгүй үнэт, ховор дурсгалаас дээжилсэн түр үзэсгэлэнг жил бүр тодорхой давтамжтайгаар гаргаж олны хүртээл болгож хэвшүүлэх.

3.4.10 Музейн нэрийн бэлэг дурсгалын дэлгүүр /үзмэрийн макетаар төрөл бүрийн бүтээл хийх, ном товхимол, цомог, хуанли, хуурцаг гаргах г.м/ ажиллуулах.

3.5 Мэргэжлийн чадавхи, бүтээлч үйл ажиллагаа, үр дүн, бодитой урамшуулалд суурилсан зарчмыг мөрдүүлэх замаар хүний нөөцийн хөгжлийг хангах.

3.5.1 Музейн мэргэжлийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох ажлыг мэргэжлийн байгууллагын хүчин туслалцаатайгаар гүйцэтгэх.

3.5.2 Мэргэжлийн шаталсан ажлын байран дээрх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.

3.5.3 Гадаад орнуудад мэргэжлээрээ урт богино хугацаагаар суралцан мэргэших, тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг судлаж, ашиглах.

3.5.4 Музейн болон өвийн боловсрол олгох, сайн дурын ажилтан бэлтгэх хөтөлбөрийг шинээр боловсруулж, хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах.

3.5.5 Эрдэм шинжилгээ судалгааны ажлын цар хүрээг тэлж, ажиллагсдын ажиллах нөхцөл боломжийг бүх талаар хангах.

3.5.6 Музейд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтнуудад үзүүлэх хөнгөлөлт, бодит урамшууллын систем бий болгож хэрэгжүүлэх.

3.5.7 Музейн дотоод, гадаад харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах.

#### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, мониторинг**

4.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар гүйцэтгэнэ.

4.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг Эрдэнэ Зуу музей хариуцаж гүйцэтгэнэ.

4.3 Хөтөлбөрийн үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг Аудитын байгууллагаар гүйцэтгүүлнэ.

#### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

5.1 “Эрдэнэ Зуу” хөтөлбөрийг 2019-2022 онд 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

#### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт**

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд:

- Улс, орон нутгийн төсөв
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, нэмэлт орлого
- “Соёл урлагийг дэмжих сан”, соёл урлагийн байгууллагыг дэмждэг ТББ



- Гадаад, дотоодын төсөл хөтөлбөр

- Хандив, тусламж

6.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан хэсэгчилсэн төлөвлөгөөг байгууллага жил бүр нарийвчлан төлөвлөн, шаардагдах зардлыг холбогдох байгууллагаар батлуулж хэрэгжүүлнэ.

### **Долоо. Хөтөлбөрийн үр дүн**

7.1 Эрдэнэ Зуугийн дурсгалт барилга байгууламжид эрсдэл учруулах сөрөг нөлөөллийн хүчин зүйлсийг тодорхойлж, түүнийг бууруулах, сэргийлэн хамгаалах боломж бүрдэнэ.

7.2 Барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлийг сэргээн засварлах, арчлан тордох, бэхжүүлэх үйл ажиллагааны чанар дээшилж, тогтмолжино. Ингэснээр түүх соёлын дурсгалт зүйлийн насжилт удааширна, үнэ цэнэ хэвээр хадгалагдан улмаар өсөн нэмэгдэнэ.

7.3 Эрдэнэ Зуу музейн харуул хамгаалалтын хүчин чадал, чадамж нэмэгдэж, ашиглагдаж буй техник технологи сайжирснаар орчны аюулгүй байдлын эрсдэл эрс буурч, музей болон түүхэн дурсгалд тавигддаг стандарт, шаардлага хангагдах нөхцөл бүрдэнэ.

7.4 Угтах орчин буюу музейн гадна доторх зам талбай, үзэсгэлэн, үзүүлэгийн танхимуудын үзэмж сайжирснаар үзэгч, аялагчдын сэтгэл ханамжийн түвшин дээшилнэ.

7.5 Байгууллагын удирдлага манлайлал, ажилтнуудын ур чадвар, бүтээлч үйл ажиллагаа сайжирч, музейн эрдэм шинжилгээ судалгаа, бүртгэн баримтжуулалт, өвийн боловсрол олгох, сургалт сурталчилгааны ажлын чанар, үр дүн сайжирна.

7.6 Музейн үйл ажиллагааны хүрээ тэлж, чадавхи дээшлэн, зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүний чанар, хүртээмж нэмэгдсэнээр үзэгч үйлчлүүлэгчийн тоо өснө.

### **Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

8.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

8.1.1 Дурсгалт барилга байгууламжид үзүүлэх орчны нөлөөллийн хүчин зүйлс бүрэн тодорхойлогдсон. Тэдгээрээс хамгаалах бодлого зорилтын хэрэгжилт тогтмолжсон байдал.

8.1.2 Сэргээн засварлалтад зарцуулах санхүүжилт тогтмолжиж, засварлагдсан объектын тоо нэмэгдсэн байдал.

8.1.3 Үзмэр цуглуулгын эд зүйлсийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлын үзүүлэлт тогтмол өсч, эрсдэл буурсан байдал.

8.1.4 Музейн гадна, дотор орчны тохижилт, үзвэр, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах талаар дэвшүүлсэн зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, үйлчлүүлэгчдийн тооны өсөлт, тэдний сэтгэл ханамжийн түвшин дээшилсэн байдал.

8.1.5 Музейн ажилтнуудын сургалтын хэрэгцээ хангагдсан, ажлын байрны нөхцөл сайжирсан, тэдэнд олгогдсон хөнгөлөлт, урамшуулал тогтмолжиж, хэмжээ давтамж нь нэмэгдсэн, шаардлагатай ажлын байрны нөхөн хангалт хийгдэж, ажил үүргийн давхардал, хийдэл, хэт ачаалал арилсан байдал.




8.1.6 Музейн зүгээс соёлын бүтээлч үйлдвэрлэл болон аялал жуулчлалын зах зээлд шинээр нийлүүлж буй бүтээгдэхүүний тоо төрөл, байгууллагын үйл ажиллагааны орлогын өсөлт, хөрөнгө оруулалтын үр ашгийн байдал.

8.1.7 Музейн хамт олон төрийн ба соёлын ажилтны ёс зүйн болон гэмт хэрэг зөрчил гаргаагүй, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдсан байдал.

8.2 Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, дараа жилийн санхүүжилтийн хэрэгцээг жил бүрийн 3 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байна.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн  
64 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



“ЭРДЭНЭ ЗУУ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөтөлбөрийн зорилго:

Эрдэнэ Зуу цогцолборын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдал, орчны тохижилт, үйлчилгээг өнөөгийн тавигдаж буй шаардлага, стандартын хэмжээнд хүргэн хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлж, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахуйц соёл, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ.

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Үр дүн	Төсөв, хаанаас /мян.төг/
Хөтөлбөрийн зорилт: 3.1							
Эрдэнэ Зуу музейн барилга байгууламжид үзүүлж буй сөрөг нөлөөллийн хүчин зүйлсийг тодорхойлох шинжилгээ судалгааг бодитой хийж, үр дүнг нь ашиглах нөхцөл бүрдүүлэх							
3.1.1	Барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлийн чанар, аюулгүй байдалд үзүүлж буй орчны болон ашиглалтын нөхцөлөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийн үнэлгээг тогтоолгох төсөл хэрэгжүүлэх	2020 оны 1-р улирал	Боловсрол, соёл урлагийн газар Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Боловсруулсан төсөл, түүний хэрэгжилтээр	Хүрээлэн буй байгаль болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр Эрдэнэ Зуу музейн цогцолборт үзүүлж байгаа, цаашид гарах сөрөг нөлөөллийн	300,0
3.1.2	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх	2020 оны 1-р улирал	Боловсрол, соёл урлагийн газар Эрдэнэ Зуу музей	Сонгогдсон судалгааны баг			-



3.1.3	Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг батлан мөрдлөг болгох	2020 онд /жилийн турш/	Боловсрол, соёл урлагийн газар Эрдэнэ Зуу музей	Сонгогдсон судалгааны баг	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	хүчин зүйлсийг бүрэн тодорхойлсон байна.	-
3.1.4	Шаардлагатай зардал төсвийг улс, орон нутгийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх	Жил бүр	Боловсрол, соёл урлагийн газар Эрдэнэ Зуу музей	Санхүү төрийн сангийн хэлтэс	Санхүүжилт	Хөтөлбөрийн зорилт 3.1 хэрэгжих санхүүжилт хийгдсэн байна	-
<p>Хөтөлбөрийн зорилт 3.2 Барилга байгууламж, үзмэр цуглуулгыг арчлан тордох, бэхжүүлэлт хийх, сэргээн засварлах хэрэгцээг тасралтгүй хангах хөрөнгө санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх</p>							
3.2.1	Барилга байгууламж, үзмэр эд өлгийн зүйлийн сэргээн засварлалтын хэрэгцээг шаардлагатай объект, өв бүрээр гарган эрэмбэлж улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж батлуулах	2020 оны эхний хагаст	Боловсрол, соёл урлагийн газар Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Судалгаа, шинжилгээ, төлөвлөлтөд хамрагдаж зураг төсөв нь хийгдсэн соёлын өвийн объектын тоо	Түүх соёлын дурсгалт барилгын насжилт уртасна	-
3.2.2	Сэргээн засварлах, арчлан тордох үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн тооцоо, санхүүжилтийн хэлбэрийг урьдчилан тогтоож, тухайн оны төсөв тус бүрт тусгуулан шийдвэрлүүлэх	2019 онд	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Батлагдсан зураг төсвийн байдлаар	Зураг төсөв хийгдсэн байна	30000,0



3.2.3	Музейн дэргэд, дурсгалт барилга байгууламж үл хөдлөх өвийг арчлан тордох, бэхжүүлэлт, урсгал засварын ажлыг тогтмол явуулах чадавхи бүхий мэргэжлийн мэргэшсэн баг байгуулж ажиллуулах	2020 онд	Эрдэнэ Зуу музей	Соёлын өвийн Үндэсний төв	Төлөвлөлт гүйцэтгэлээр	Соёлын өвийг сэргээн засварлаж, хадгалалт хамгаалалт сайжирсан байна.	Гэрээт ажилтны цалин урамшуулал
3.2.4	Үзмэр эд өлгийн зүйлийн сэргээн засварлалтын хэрэгцээг хангах асуудлыг Соёлын өвийн Үндэсний төвтэй жил бүр “Хамтран ажиллах гэрээ” байгуулан мөрдөх замаар шийдвэрлэх	Хөтөлбөр хэрэгжих хугацаанд	Эрдэнэ Зуу музей				-
Хөтөлбөрийн зорилт 3.3 Үзмэр эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлыг хангахад ашиглагдах техник хэрэгсэл, хүний нөөцийг улсын онцгой объектод тавигдах нөхцөл шаардлагын хэмжээнд хүргэх							
3.3.1	Музейн харуул хамгаалалтын үүргийг цагдаагийн эсвэл мэргэжлийн хамгаалалтын албанд шилжүүлэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар Боловсрол, соёл урлагийн газар	Бүтэц орон тоогоор	Хамгаалалт эрс сайжирна	95000,0
3.3.2	Телекамераар хянах талбайн хэмжээгээ үе шаттайгаар нэмэгдүүлэх	2019-2021 онд	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар Боловсрол, соёл урлагийн газар	Техникийн хүчин чадлын үзүүлэлтээр	Соёлын өвийг хамгаалахад ахиц гарсан байна.	10000
	Дохиоллын системийн			Аймгийн	Үйл		



3.3.3	ажиллагааны найдвартай байдал, бичлэгийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, багтаамжийг сайжруулах	Хөтөлбөр хэрэгжих хугацаанд	Эрдэнэ Зуу музей	Засаг даргын Тамгын газар Боловсрол, соёл урлагийн газар	ажиллагааны үзүүлэлтээр		7500.0
3.3.4	Гал унтраах автомат ажиллагаатай багаж төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар Боловсрол, соёл урлагийн газар	Техникийн хүчин чадлын үзүүлэлтээр	Соёлын өвийг хамгаалах технологид ахиц гарсан байна.	2500.0
3.3.5	Сан хөмрөгийн өрөө тасалгааг өргөжүүлж, тавиур, сейфний тоог нэмэх, үзмэр цуглуулгыг төрөлжүүлэн хадгалах	2020 онд	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар Боловсрол, соёл урлагийн газар			3500.0
3.3.6	Сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх, үзмэр зөөж тээвэрлэх шаардлага гарсан тохиолдолд ашиглах зориулалт бүхий тусгай хайрцаг сав бэлтгэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар Соёлын өвийн Үндэсний төв Боловсрол, соёл урлагийн газар	Тоног төхөөрмжийн тоо хөрөнгө оруулалтын хэмжээгээр	Музейн стандарт хэрэгжинэ.	850.0
3.3.7	Үзэсгэлэн болон үзмэрийн танхимуудын шилэн хорго, хаалт ханыг боловсронгуй болгон шинэчлэх	2020-2022 онд	Эрдэнэ Зуу музей				16000.0
3.3.8	Үзмэр цуглуулгын орчны дулаан, чийгшил хэмжих багаж төхөөрөмжийн хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	2020 онд	Эрдэнэ Зуу музей				12000.0



Хөтөлбөрийн зорилт 3.4. Музейн үзвэр үйлчилгээ, үйл ажиллагаанд соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:										
3.4.1	Угтах орчны тохижилт /зам талбай, сандал сүүдрэвч, дурсгалын зураг татуулах тавцан г.м/	2020 онд	Эрдэнэ Зуу музей	Аймгийн Засаг даргын Тамгын газар Боловсрол, соёл урлагийн газар Гүйцэтгэгч байгууллага	Хөрөнгө оруулалтын хэмжээгээр	Музейн үйлчилгээ үзүүлэх, авах орчин нөхцөл сайжирсан байна.	40000.0			
3.4.2	Хэрмийн дотор талбайд байрлуулсан мэдээлэл, сурталчилгааны самбаруудыг зохистой болгох, шаардлагатай таних тэмдэг тэмдэглэгээг хийж байрлуулах	2019-2020 онд	Эрдэнэ Зуу музей				2000.0			
3.4.3	Музейн ерөнхий болон үзүүллэгт байгаа үзмэрийн тайлбарыг агуулга, зохиомжийн хувьд боловсронгуй болгох	2020 оноос	Эрдэнэ Зуу музей				-			
3.4.4	Аудио хөтөчийн үйлчилгээг нэвтрүүлэх, мөн аман тайлбарыг орос, япон, хятад хэл дээр хүргэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2020-2021 онд	Эрдэнэ Зуу музей				2 тайлбарлагч орон тоо /цалингийн төсөв/			
3.4.5	Виртуаль орчинд дахь үзүүллэгийн агуулга, хүртээмжийг нэмэгдүүлэх	2020 – 2023 он	Эрдэнэ Зуу музей				1000.0			
3.4.6	Бурханы шашны соёлын бодит өвийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хийдтэй хамтран тусгайлсан орчинд явуулах	2019 - 2022 он	Эрдэнэ Зуу музей				Эрдэнэ Зуу музей	Үйлчлүүлэгсдийн тоогоор	Музейн үйл ажиллагаа сайжирна	-
3.4.7	Тусгай үзэгчдэд /буддистууд, бурханы	2020 оноос	Эрдэнэ Зуу музей							БатЭрдэнэ Зуу хийд



	шашин судлаач нар, энэ чиглэлийн оюутан сурагч/ ламаар музейн тайлбар хийлгэх						
3.4.8	Хийдийн нандин сахиус, бусад хосгүй үнэт, ховор дурсгалаас дээжилсэн түр үзэсгэлэнг жил бүр тодорхой давтамжтайгаар гаргаж олны хүртээл болгож хэвшүүлэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	БатЭрдэнэ Зуу хийд			-
3.4.9	Музейн нэрийн бэлэг дурсгалын дэлгүүр /үзмэрийн макетаар төрөл бүрийн бүтээл хийх, ном товхимол, цомог, хуанли, хуурцаг гаргах г.м/ ажиллуулах	Хөтөлбөр хэрэгжих хугацаанд	Эрдэнэ Зуу музей				3000.0
<p>Хөтөлбөрийн зорилт 3.5 Мэргэжлийн чадавхи, бүтээлч үйл ажиллагаа, үр дүн, бодитой урамшуулалд суурилсан зарчмыг мөрдүүлэх замаар хүний нөөцийн хөгжлийг хангах</p>							
3.5.1	Музейн мэргэжлийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох ажлыг мэргэжлийн байгууллагын хүчин туслалцаатайгаар гүйцэтгэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей		Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоогоор	Хүний нөөц сайжирсан байна.	500.0
3.5.2	Мэргэжлийн шаталсан ажлын байран дээрх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей				Тухайн жилийн хэрэгцээгээр
3.5.3	Гадаад орнуудад	2020	Эрдэнэ Зуу музей				-



	мэргэжлээрээ урт богино хугацаагаар суралцан мэргэших, тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг судалж, ашиглах	оноос		сургалт		
3.5.4	Музейн болон өвийн боловсрол олгох, сайн дурын ажилтан бэлтгэх хөтөлбөрийг шинээр боловсруулж, хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	Ажилчдад олгосон хөрөнгө оруулалтын хэмжээгээр	Музейн ажилчдын чадавхи дээшилнэ.	Нэг жилд 20000.0
3.5.5	Эрдэм шинжилгээний ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг хангаж, судалгааны ажлыг тогтмолжуулах	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	Ажлын бүтээмжээр		Нэг жилд 4000.0
3.5.6	Музейд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтнуудад үзүүлэх хөнгөлөлт, бодит урамшууллын систем бий болгож хэрэгжүүлэх	2020 оноос	Эрдэнэ Зуу музей			Нэг жилд 1000.0
3.5.7	Музейн дотоод, гадаад харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах	2020 оноос	Эрдэнэ Зуу музей	Үйл ажиллагааны үзүүлэлтээр		-